

ЭРДЭНЭ РЕСУРС БАЯН ХӨНДИЙН АНХДАГЧ УУРХАЙН БҮСЭД ӨНДӨР АГУУЛГАТАЙ АЛТ ИЛРҮҮЛЭВ

Онцлох нь:

- Баян Хөндий Алтны Төслийн анхдагч уурхайн бүсийн хэд хэдэн цооногт газрын дөт гүнд алтны өндөр агуулга бүхий интервалууд огтлов.
 - 68.0 г/ алтны агуулга бүхий 2 метрийн интервал багтаасан 14.4 г/т алтны агуулга бүхий 10 метр . (BKD-361)
 - 32.6 г/т алтны агуулга бүхий 2 метр интервал багтаасан 10.4 г/т алтны агуулга бүхий 20 метр. (BKD-369)
 - 67.5 г/т алтны агуулга бүхий 1 метр интервал багтаасан 11.8 г/т алтны агуулга бүхий 7 метр. (BKD-354)
 - 39.6 г/т алтны агуулга бүхий 1 метрийн интервал багтаасан 5.7 г/т алтны агуулга бүхий 10 метр огтоллоо. (BKD-356)

Хэвлэлийн мэдээ

Нова Скошиа муж, Халифакс хот
2022.10.25

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци (TSX: ERD | MSE: ERDN) (“Эрдэнэ Ресурс” эсвэл “Компани”) нь Монгол Улсын баруун өмнөд бүсэд орших өөрийн 100% эзэмшлийн Хөндий Алтны Дүүрэг (“Дүүрэг”)–ийн өндөр агуулгатай ба газрын дөт гүнд орших Баян Хөндий алтны ордод 2022 оны 3-р улиралд гүйцэтгэсэн өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг танилцуулахад таатай байна.

Тодруулга

Эрдэнэ Ресурсийн ерөнхийлөгч ба гүйцэтгэх захирал Петер Акерли хэлэхдээ: “Баян Хөндий ордын ТЭЗҮ–ийг боловсруулснаас хойш гүйцэтгэсэн хайгуулын өрөмдлөг болон Хар Морь талбайн шинэ нээлтээр энэхүү хоёр орд нь газрын гадаргад ойр, маш өндөр алтны агуулгатайг баталгаажуулсан. Эдгээр өндөр агуулгатай бүсүүд нь Баян Хөндийн хөгжүүлэлтийн анхдагч уурхайн хэсэг байх төлөвтэй байна.”

Петер Акерли үргэлжлүүлэн: “Өнөөдрийн танилцуулж буй хөтөлбөр нь Баян Хөндий ордыг ашиглахаар 3 үе шаттайгаар төлөвлөсөн ил уурхайн талбайд маш өндөр агуулга бүхий алт нь газрын гадаргаас эхэлж буйг баталж, нэмэлтээр боловсруулалтын туршилтуудыг хийх шаардлагатайг харууллаа. Энэхүү боловсруулалтын туршилт, судалгаагаар оны эхэнд гүйцэтгэсэн ганд уусгах технологийн хамт гравитацийн аргаар боловсруулах боломжтойг танилцуулсан анхан шатны судалгааг өргөжүүлж, үйл ажиллагааны зардлыг бууруулж, мөнгөн урсгалыг урагшлуулах боломжтой.”

“Баян Хөндийн газрын дөт гүн дэх хөгжүүлэлтийн ажлаас гадна Хар Морь талбайд төстэй ажлууд хийгдэж байгаа бөгөөд Улаан, Хар Морь талбайд гүйцэтгэсэн

хайгуулын өрөмдлөгийн хөтөлбөрийн үр дүнг 4-р улирлын дундуур танилцуулна. Бид Баян Хөндий алтны төслийг бүтээн байгуулалтын шат руу ахиулахаас гадна Дүүргийн хэмжээнд нөөцийг нэмэгдүүлэх хайгуулын ажлуудыг гүйцэтгэсээр байна.”

Анхдагч уурхайг тодорхойлох өрөмдлөгийн хөтөлбөрийн хураангуй

2022 оны 3-р улиралд гүйцэтгэсэн Баян Хөндийн өрөмдлөгийн хөтөлбөр нь Баян Хөндий алтны төслийн (“Төсөл”) анхан шатны хөгжүүлэлтийн талбайн газрын дөт гүн дэх өндөр агуулга бүхий хүдэржсэн бүсүүдийг баталгаажуулах зорилготой. Түүнээс гадна, ганд уусгах технологиор боловсруулах үйлдвэр (CIP)-ээс гадна гравитацийн аргаар боловсруулах боломжтой хүдрийн нөөцийг тодорхойлох зорилготой байв.

Эрдэнэ Ресурс нь 2022 оны 3-р улиралд Баян Хөндийн төлөвлөсөн уурхайтай ойр зорилтот гурван талбайд газрын дөт гүнд нийт 612 метр (дунджаар 17 метрийн босоо гүнд) 25 PQ алмазан цооногоос бүрдсэн өрөмдлөгийн хөтөлбөрийг гүйцэтгэсэн. Энэхүү хөтөлбөрийн зорилго нь Баян Хөндий ордын Зүүн Өмнөд Мидфийлд, Өмнөд Страйкер, Страйкер бүс дэх газрын дөт гүнд, маш өндөр агуулгатай талбайд анхдагч уурхайн бүсийг тодорхойлон, агуулга, бүтэц тасралтгүй үргэлжилж буйг тодорхойлон, гравитацийн аргаар боловсруулахад металлургийн туршилт хийх дээж цуглуулах байв.

Өрөмдлөгийн хөтөлбөрөөр хэд хэдэн өндөр агуулга бүхий интервалууд огтолсон нь Зүүн Өмнөд Мидфийлд, Өмнөд Страйкер болон Страйкер бүсэд газрын дөт гүнд өндөр агуулга бүхий бүсүүд тасралтгүй үргэлжилж буйг баталгаажуулсан. Доорх хүснэгт 1-т харуулснаар 10 г/т агуулгаас өндөр алтны агуулга бүхий хэд хэдэн цооногуудыг огтолсон. Энэхүү үр дүнгүүдийг шинэчилсэн загварчлалд тусгаж, уурхайн хөгжүүлэлтийн төлөвлөлтөд ашиглана. Мөн цооногуудын дээжийг одоогийн төлөвлөж буй боловсруулах үйлдвэрээс гадна гравитацийн аргаар боловсруулах боломжийг судлах металлургийн судалгаанд ашиглана.

Хүснэгт 1: Баян Хөндийн өрөмдлөгийн хөтөлбөрийн онцлох үр дүнгүүд (10 г/т алтны агуулгаас дээш интервал бүхий цооногийн мэдээллүүдийг танилцуулав)

Цооног	м-ээс	м хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
BKD-352	6.5	26	19.5	2.51
Түүнд	18	23	5	6.20
Түүнд	19	20	1	15.06
BKD-354	0	7	7	11.79
Түүнд	5	6	1	67.54
BKD-356	6	25.6 ⁽²⁾	19.6	3.10
Түүнд	7	17	10	5.72
Түүнд	15	16	1	39.60
BKD-358	10.3	26 ⁽²⁾	15.7	8.03
Түүнд	12	16	4	29.60
Түүнд	14	15	1	100.46
BKD-361	5	15	10	14.36

Түүнд	10	12	2	67.95
BKD-363	12	18	6	1.97
Түүнд	17	18	1	10.05
BKD-366	23	29.5 ⁽²⁾	6.5	3.78
Түүнд	25	26	1	11.27
BKD-368	1	26 ⁽²⁾	25	1.00
Түүнд	2	3	1	16.96
BKD-369	0	20 ⁽²⁾	20	10.44
Түүнд	0	1	1	17.88
Түүнд	4	7	3	27.04
Түүнд	9	11	2	32.57
Түүнд	15	16	1	10.18
BKD-370	2.5	20 ⁽²⁾	17.5	4.78
Түүнд	2.5	9	6.5	10.64
Түүнд	6	7	1	30.51
Түүнд	8	9	1	10.89
BKD-371	0	5	5	9.27
Түүнд	1	3	2	21.45
BKD-372	0	5	5	1.13
Ба	18	22	4	5.69
Түүнд	19	20	1	12.02

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
2. Цооногийн төгсгөл

Зүүн Өмнөд Мидфийлд Бүс

Зүүн Өмнөд Мидфийлд (ЗӨМ) бүсийн өрөмдлөгөөр газрын гадаргуугаас 25 метрт алтны өндөр агуулгатай хүдэржилтийг шалгах 9 цооног өрөмдсөн. ЗӨ Мидфийлд бүсэд урьд гүйцэтгэсэн өрөмдлөгийн үр дүнд Баян Хөндий ордын газрын дөт гүн дэх хамгийн өндөр агуулгатай хүдэржилт нь BKD-288 цооногийн 11.5 метрээс эхлэн 581.6 г/т алтны агуулгатай 1 метр, түүнийг багтаасан 125.9 г/т алтны агуулга бүхий 5.5 метр интервал огтолсон бөгөөд BKD-274 цооногийн 15 метрийн гүнд 74.34 г/т алтны агуулгатай 5 метр интервал, түүнийг багтаасан 25.6 г/т алтны агуулга бүхий 15.1 метр огтолсон. ЗӨ Мидфийлд дэх алтны хүдэржилт нь Баян Хөндий ордын туфлаг үндсэн нэгжийг хөндлөн огтолж буй баруун өмнө зүг дэх цахиур-гематит эпитеpmийн судалтай холбоотой юм. ЗӨ Мидфийлдийн алтны агуулга нь супергенээр баяжин, тэр дундаа алт агуулагч анхдагч эпитеpmаль судал нь хойд-өмнөд чиглэлтэй структурын хавтгай дагуу огтолсон бүсэд багтдаг. Энэхүү хавтгай дагуу баяжилт нь ихэвчлэн 100 г/т алтны агуулгаас дээш агуулга бүхий брекчсэн болон өргөн тархсан гематит цөмд агуулагддаг.

Страйкер болон Өмнөд Страйкер Бүс

Страйкер болон Өмнөд Страйкер Бүсэд тус бүр 6 ба 10 цооног өрөмдсөн. Өмнө нь танилцуулсан цооногууд болох VKD-44 цооногийн 0.7 метрийн гүнээс эхлэн 93 г/т алтны агуулгатай 1 метр, түүнийг багтаасан 14 г/т алтны агуулгатай 8.3 метр, VKD-292 цооногийн 0.9 метрийн гүнээс эхлэн 29 г/т алтны агуулгатай 15.1 метр, VKD-46 цооногийн 8 метрээс эхлэн 10 г/т алтны агуулга бүхий 7 метрийн интервал зэрэг газрын дөт гүнд өндөр агуулга бүхий алтны хүдэржилтийг үргэлжлүүлэн тодорхойлсон.

Страйкер болон Өмнөд Страйкер бүсүүдийн алтны хүдэржилт нь Баян Хөндий ордын туфлаг үндсэн нэгжийг хөндлөн огтолсон баруун өмнө зүг рүү унасан кварц-адуляр± гематит эпитеpmаль судалтай холбоотой. Өмнөд Страйкер бүсэд ажиглагддаг алтны агуулга нь туфлаг агуулагчийг шингээсэн монодиорит очлуурын ауреолийн доторх маш өндөр агуулгатай (VKD-292 цооногт 353 г/т хүртэл алтны агуулга бүхий интервал илэрсэн). Өнөөгийн тайллаар алтны агуулгын баяжилт нь интрузив биетийг хүрээлсэн монзодиоритын байршлын үе шатанд структур болон гидротермаль процесстэй холбоотой алтны дахин үүссэн үе давхарга болон хөдөлгөөнтэй холбоотой.

Металлургийн судалгаа

Баян Хөндий ордын боловсруулах технологийн нэг хэсэгт гравитацийн шийдлийг ашиглах талаар анхан шатны үнэлгээнээс хойш судлагдсан. 2020 онд илрүүлсэн 3Ө Мидфийлд, Өмнөд Страйкер талбай дахь газрын дөт гүнд маш өндөр агуулгатай алтны интервалууд болон Хар морь талбайд илрүүлсэн газрын гадаргад өндөр агуулга бүхий алтны нээлт зэрэгт үндэслэн Эрдэнэ Ресурсийн техникийн баг 2022 оны дундуур гравитацид тулгуурласан металлургийн судалгааг үргэлжлүүлэн гүйцэтгэж байна. Судалгааны үр дүнг доор тоймлон харуулав.

3Ө Мидфийлд болон Өмнөд Страйкер талбайд гүйцэтгэсэн өрөмдлөгийн цооногийн дээжээс нийлмэл дээжийг сонгосон. Энэхүү нийлмэл дээж нь 15.1 г/т дундаж алтны агуулга бүхий 13 цооногоос 21 ширхэг 1 метрийн интервалын 1/4-ээс бүрдсэн. Нийлмэл дээжийг Баян Хөндий төслийн металлургийн судалгааны дийлэнх хэсгийг гүйцэтгэдэг Бритиш Колумбын Парксвилл дэх Blue Coast Research компани шинжилсэн. Шинжилгээнд нийлмэл дээжээс гравитацийн аргаар авах боломжтой металлын хэмжээг тодорхойлох Гравитацийн Өргөтгөсөн Туршилт (EGRG)-ын аргыг ашигласан. Шинжилгээг гурван үе шаттай буюу нунтаглах хэмжээг нарийсган (850 микрон, 250 микрон болон 75 микрон), Knelson MD-3 баяжуулагчаар дамжуулан судалсан. Шинжилгээний үр дүнд гравитацийн аргаар алт авалт 74.6%-тай байна.

EGRG шинжилгээний өгөгдлийг FLSmidth Knelson-нд хүргүүлэн хянуулж байна. FLSmidth Knelson боловсруулсан загварчлалаар олон төрлийн хэлхээний тохируулга, үйлдвэрийн загварчлал, параметруудийн хүрээнд гравитацийн аргаар алт авалтыг таамаглах зорилготой. Дээрх загварчлалаар шигшилт (50%), эрчимжүүлсэн уусгалтын реактор (60%) ашиглан металл авах боломжтойг харуулсан.

2022 оны дунд гүйцэтгэсэн туршилтын үр дүнд үндэслэн зургаан нийлмэл материалыг үргэлжлүүлэн туршина. Тус туршилтын нийлмэл дээжийг PQ өрөмдлөгийн хөтөлбөрийн дээжээс авна. Нэмэлтээр хийгдэх судалгаанд өөр өөр талбайн өөр өөр агуулгатай зургаан төрлийн дээжийг сонгон EGRG болон шигшин баяжуулах аргаар турших туршилт багтана. Дээрх өгөгдлүүд нь Баян Хөндий ордын хүдрийг олборлох хамгийн үр дүнтэй гравитацийн аргаар баяжуулах хэлхээг тодорхойлохоос гадна ганд уусгах технологи бүхий боловсруулах үйлдвэрийн урд гравитацийн хэлхээг нэмэхэд дэмжлэг үзүүлнэ.

Эрдэнэ Ресурсийн өнөөг хүртэл гүйцэтгэсэн судалгаанд тулгуурлан боловсруулах үйлдвэрийг бүрэн ашиглалтад оруулахаас өмнө гравитацийн аргаар баяжуулах хэсгийг ашиглалтад оруулж, бэлэн мөнгөний урсгалыг урагшлуулан, анхан шатны хөрөнгө оруулалтын зардлыг хурдан нөхөх боломжтой саналыг дэвшүүлсэн. Цаашилбал, гравитацийн аргаар баяжуулах хэлхээг боловсруулах үйлдвэртэй нэгтгэн, доод урсгалын элюцийн ачааллыг бууруулж үйлдвэрийн хүчин чадлыг нэмэгдүүлэх боломжтой. Гравитацийн аргаар баяжуулах хэлхээг БНХАУ-ын хэд хэдэн үйлдвэрлэгчдээс угсрах боломжтойгоор авах нь хурдан бөгөөд хямд төсөв өртгөөр хийгдэх ач холбогдолтой.

Төслийн тухай

Эрдэнэ Ресурсийн ордууд нь дэлхийн томоохон алт, алт-зэсийн ордуудыг агуулагч Төв Азийн Орогены бүсэд багтдаг Эдрэнгийн төрөйнд байрладаг. Компани нь Монгол Улсын баруун өмнөд хэсэгт 10 гаруй жил хайгуул судалгааг хийн, өдгөө Хөндий алтны дүүргийг нээн илрүүлсэн. Хөндий алтны дүүрэг нь өндөр агуулга бүхий алт, полиметаллын хэд хэдэн хэтийн төлөвт талбайг хамардаг Баян Хөндий, Алтан Нар ордуудыг ашиглалтын шатанд хүртэл хөгжүүлэхээр зорьж байна. Хөндий Дүүрэг нь Транс Алтайн Төрөйн (Эдрэнгийн Төрөйн)-д 40км*20км талбайд гүехэн субдукцын Палеозойн интрузив үйл явдалтай холбоотой гурван алт болон суурь металлын системд тулгуурладаг. Эрдэнэ Ресурсийн 2022 оны хайгуулын хөтөлбөр нь дараах хоёр алтны системд чиглэнэ:

Баян Хөндий (Rich Valley): Бага сульфид эпитеpmаль алтны орд болон хэтийн төлөв бүхий талбай (Баян Хөндий орд, Хар Морин Дэл, Улаан болон Алтан Сум) нь өндөр агуулга, интрузив хамааралтай хувирлын бүсээр тодорхойлогддог. 12 км трендийн дагуу байрладаг ордуудыг бүс нутгийн тэлэлтийн бүс болон судлын хагарлын системийн дагуу зүүн хойд трендийн структурт чиглэсэн гүн бүтэцтэй холбоотой хэмээн тайлбарладаг. Баян Хөндий алтны ордын нөөц: 2.19 г/т дундаж алтны агуулга бүхий 585,100 унц баттай болон бодитой геологийн нөөц¹ (“Measured and Indicated Resources”)², 2.18 г/т алтны агуулга бүхий 35,900 унц боломжит нөөц (“Inferred Resources”)³ тодорхойлогдсон. Хар Морин Дэл, Улаан болон Алтан Сум талбайд нөөцийн тооцоолол хийгээгүй байна.

Шинээр нээн илрүүлсэн Хар Морин Дэл болон Улаан нээлтийн тухай мэдээллийг доор танилцуулав.

Хар Морин Дэл

Эрдэнэ Ресурс нь 2021 онд алтны хүдэржилт болон хувирал бүхий 1.5 км трендийг нээн илрүүлсэн нь өнөөгийн Хар Морин Дэл юм. Баян Хөндий ордоос хойд зүгт 2.4 км-т орших энэ бүсийн хүдэржилт нь газрын гадаргаас эхэлдэг бөгөөд өмнө зүгт 20-60 метрийн босоо гүнд өргөн, хагарлын дагуу гүндээ исэлдэн, 123 г/т алтны агуулга бүхий 5 метрийн интервал (AAD-178) зэрэг маш өндөр алтны агуулга бүхий бүсийг агуулсан супергенээр баяжсан талбайд хамаардаг. Өндөр агуулга бүхий исэлдсэн хүдрийн биет нь хойд-өмнөд судлын дагуу үргэлжилж байгааг харуулсан. Хүдэржилт нь судлын дагуу болон гүндээ нээлттэй. Хязгаарлагдмал хийгдсэн гүний өрөмдлөгөөр алтны хүдэржилтийн зузаан бүсүүдийг босоо гүнд 230 метр хүртэл (жишээ нь AAD-57, цооногийн 194 метрт 1.18 г/т алтны агуулга бүхий 48 метр) огтолсон нь эпитеpmаль судал, цагаан гялтгануурын хувирал болон сульфидын хүдэржилттэй холбоотой бөгөөд гүндээ нээлттэй.

Компани нь 2021 оны эцэс, 2022 оны эхэнд Хар Морь талбайд өгөгдөл цуглуулах, тайллын судалгаа болон өрөмдлөгийн хөтөлбөр тодорхойлох ажлуудыг гүйцэтгэсэн. Энэхүү ажлууд нь алтны аномализм, тэжээгч структурыг тодорхойлох, гүехэн алтны исэлдсэн хүдэржилт, Хар Морин Дэлтэй ижил чанартай талбайг тодорхойлох болон алтны хүдэржилтийн гүний бүсүүдийг тодорхойлоход чиглэсэн. Дээрх судалгаагаар 2022 онд судлах хэд хэдэн өрөмдлөгийн талбайг ялгасан.

Улаан

Улаан нээлтийг 2021 оны 3-р улиралд гадаргын эрдэсжилтгүй нөхцөлд нээн илрүүлсэн. Нээлт нь 200*250 метрийн талбайг хамарсан хэдэн зуун метрийн алтны хүдэржилтээр (нэг цооногт 354 метр хүртэл) тодорхойлогддог. Алтны хүдэржилт нь 80 метрийн гүнээс эхэлдэг, баруун-баруун хойд зүгт судлын дагуу болон гүндээ нээлттэй. Үүнд UDH-22 (85 метрээс) цооногт 1.7 г/т алтны агуулга бүхий 152 метр, UDH-21 (115 метрээс) 3.2 г/т алтны агуулга бүхий 77 метрийн интервалууд огтолсон. Талбайн зүүн талд 300 метрт орших Баян Хөндий алтны ордын шинж чанартай ижил, маш өндөр агуулга бүхий кварц ± гематит, адулярын судал болон цагаан гялтгануурын хувиралтай лапилли туфтай ижил зузаалагт агуулагдаж буй штокверк бүсээр тодорхойлогддог. 156.5 г/т хүртэл алтны агуулга нь агуулагч структур болон тэжээгч бүсүүдтэй холбоотой кварц±гематитын судлууд, штокверк бүсүүдэд тохиолдоно. Улаан нээлтийн хойд хэсэгт илрүүлсэн штокверк бүс нь 2022 оны 2-р улирлын хайгуулын бүс болох бөгөөд 20 г/т алтны агуулга бүхий 5 метр (UDH-14), 156 г/т алтны агуулга бүхий 1 метр (UDH-21) интервалууд агуулсан өргөн бүсүүд болох 8.74 г/т алтны агуулга бүхий 27 метр (UDH-21), 5.43 г/т алтны агуулга бүхий 34 метр (UDH-14) бүхий цооногуудын чиглэл болон цар хүрээг тодорхойлохоор зорьсон. Түүнээс гадна 2022 оны хайгуулын хөтөлбөрөөр Зүүн Өмнөд Улаан талбайд өргөтгөлийн өрөмдлөгөөр одоогийн байгаа цооногуудыг гүндээ үргэлжилж буйг шалгах хэд хэдэн өрөмдлөг гүйцэтгэхээр төлөвлөсөн. Энэхүү өрөмдлөгийг одоогоор гүйцэтгэж байна.

Улаан тусгай зөвшөөрлийн талбайн өмнөд хэсэгт 3.5км*1км талбайд аномаль хөрсний алт бүхий бүсүүд байдаг. Суурь геологи, хувирлаас харахад Зүүн Өмнөд

Улаан, Баян Хөндийн алтны хүдэржилт нь цагаан гялтгануур болон цахиурын хувирал бүхий туфын нэгжүүдтэй төстэй.

Алтан Нар (Golden Sun): Дундаж сульфид, карбонатлаг суурь металлын алтны орд ба хэтийн төлөв бүхий талбай нь Хойд-Зүүн хойд тренд структурын коридорт багтдаг геохимийн аномаль хувирлын бүсэд 5.6 км урт талбайг хамран оршдог. Олон структурын огтлол нь тэлэлтийн бүсийг үүсгэж, хүдэржилтийн өргөн бүсүүд бий болох нөхцөлийг бүрдүүлсэн. Алтан Нарын нөөцөд 2.0 г/т алтны агуулга бүхий 317,700 унц бодитой нөөц, 1.7 г/т алтны агуулга бүхий 185,700 унц боломжтой нөөц тодорхойлогдсон.

Компанийн тухай

Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Монгол Улсад суурь болон үнэт металлын хайгуул, төсөл хөгжүүлэлтийн үйл ажиллагаа эрхэлдэг Канад Улсад бүртгэлтэй хайгуулын компани. Компани нь Монгол Улсын баруун урд бүсэд хайгуулын 1, ашиглалтын 3 тусгай зөвшөөрлийг эзэмшдэг бөгөөд эдгээр хайгуулын бүсэд хийсэн судалгааны үр дүнд Хөндий Алтны Дүүргийг нээн илрүүлсэн. Эрдэнэ Ресурс Девелопмент Корпораци нь Торонто болон Монголын хөрөнгийн биржүүд дээр бүртгэлтэй. Компанийн тухай дэлгэрэнгүй мэдээлэлтэй Компанийн вебсайт www.erdene.com -оос танилцах боломжтой. Компанийн талаарх чухал мэдээллүүд нь зөвхөн Компанийн вебсайтаар дамжин хүрдэг тул хөрөнгө оруулагчид вебсайтаар дамжуулан бодит мэдээлэл авахыг зөвлөж байна.

Мэргэшсэн этгээд (геологич) ба дээжлэлтийн протокол

Петер Далтон (Peter Dalton) нь Компанийн ахлах геологич (P.Geo, Nova Scotia) бөгөөд NI 43-101-т заасан мэргэшсэн этгээд ба урьдчилсан ТЭЗҮ, АШЭЗТ-оос бусад техникийн мэдээлэл, Баян Хөндийн эрдсийн баялаг, нөөцөөс бусад мэдээ мэдээллийг Эрдэнэ Ресурсийн зүгээс хянан баталгаажуулсан болно. Бүх дээжийг Улаанбаатар хот дахь Эс Жи Эс ("SGS") лабораторид шинжлүүлсэн. Эс Жи Эс лабораторийн дотоод хяналт шалгалтаас гадна, Компани нь тусгай стандарт бэлдэц, хээрийн болон лабораторийн хуулбар, мөн хүдэржилтгүй бэлдцийг ашиглан дээжийн чанарын хяналт, баталгаажуулалт ("QA/QC")-ын протоколыг гүйцэтгэсэн. Бүх дээжид алтны агуулгыг стандарт Хайлуулах аргаар (fire assay), бусад 33 химийн элементийг Индукцын хос плазмит спектрометрийн арга (Inductively Coupled Plasma Optical Emission Spectroscopy) ашиглан тогтоосон. 5 г/т алтны агуулгаас дээш агуулга илэрсэн дээжүүдэд алтны шигшүүрийн шинжилгээ (screen-metallic gold analysis) хийсэн ба энэ нь 500 гр дээжний 75 микроноос бага байх 30 гр бүхий 3 дээж болон 75 микроноос том байх хэсгүүдэд хийгдсэн алтны хайлуулах (fire assay) шинжилгээнүүдийн жигнэсэн дунджаар илэрхийлэгддэг.

Эрдэнийн дээжлэлтийн протокол нь (хүдэржилт болон чулуулгийн төрлөөс хамаарч) зарим нэг жижиг, хүдэржилтийн дараа үеийн чулуулаг болон хүдэржилтгүй боржинг алгассан, 1 эсвэл 2 метрийн интервалтайгаар, цооногийг бүтнээр нь хамарсан дээжлэлтээс бүрддэг. Дээжлэлтийн интервалыг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэдэг ба геологийн хяналт эсвэл хүдэржилтээс хамаардаггүй болно. Бүх

дээжийг чөмгөн дээжний гүний метр дээр үндэслэн алмазан хөрөөгөөр 2 тэнцүү хуваадаг. Хуваагдсан дээжийн талыг дээжний уутанд ялган авч дээжилдэг бөгөөд үлдсэн талыг нь дээжний хайрцагт үлдээн Компанийн Баян Хөндий дэх хээрийн ангид аюулгүй байдлыг ханган хадгалдаг. Бүх дээжийг нэг багцандаа 30 дээж байхаар хуваарилдаг ба багц болгонд стандарт бэлдэц, хүдэржилтгүй бэлдэц, лабораторийн хуулбар болон хээрийн хуулбар дээж буюу дээжийг 4 хуваан, 2-ыг нь 2 тусад нь дээжлэн Улаанбаатар дахь Эс Жи Эс (“SGS”) лаборатори руу шууд тээвэрлэдэг. Тээвэрлэлтийг Эрдэнэ Ресурсийн ложистикийн гэрээт Монруд ХХК гүйцэтгэдэг.

Тайлагнасан интервал нь бодит зузаан бөгөөд өөрөөр хэлбэл цооногийн өргөн юм. Улаан талбайн өрөмдлөгийн цооногуудыг 85 градусын уналаар өрөмдсөн ба алт агуулсан судлын баруун-хойд баруун трендийн дагуу баруун урд уналын дагуу чиглэсэн. Бодит өргөнийг баталгаажуулахын тулд нэмэлт судалгаа хийх шаардлагатай. Интервалуудын тайлагнасан агуулга нь түүвэр интервалын уртад үндэслэсэн жигнэсэн дундаж үзүүлэлтүүд юм. Дээд хязгаарлалт хийгээгүй боловч 10 г/т болон 100 г/т алтны агуулгаас өндөр агуулга бүхий интервалыг тодруулахаар тусад нь тайлагнадаг.

Урьдчилсан таамаглал

Зарим мэдээллүүд нь Үнэт цаасны хуулийн хүрээнд урьдчилсан таамаглалуудыг агуулсан болохыг үүгээр мэдэгдэж байна. Урьдчилсан таамаглал нь урьд болж байсан болон ирээдүйд болох бодит баримт биш ба зөвхөн ирээдүйн төлөвлөгөө, стратеги, төсөл, нөхцөл байдалд тулгуурласан үзэл баримтлал, магадлал болон таамаглал болно. Энэхүү таамаглалууд нь тодорхой үндэслэлд тулгуурласан боловч баталгаа биш юм. Компанийн үйл ажиллагаа нь олон хүчин зүйлээс шалтгаалах бөгөөд зарим хүчин зүйлс нь Компанийн хяналтаас давсан байх магадлалтай ирээдүйд учирч болох хүчин зүйлс юм. Материаллаг өөрчлөлт үзүүлэх боломжтой хүчин зүйлсэд эрдсийн зах зээлийн үнэ, хайгуулын үр дүнгүүд, бизнесийн болон зах зээлийн орчин, эдийн засгийн байдал болон санхүүжилт, хөрөнгө босголт зэрэг орно. Дээр дурдсан мэдээллүүд нь ирээдүйд өөрчлөгдөн хувирах магадлалтай. Компани нь Үнэт цаасны хуульд өөрөөр заагаагүй тохиолдолд Урьдчилсан таамаглалыг өөрчлөн, шинэчлэх үүрэг хүлээхгүй.

Энэхүү хэвлэлийн мэдээ нь англи хэл дээр бэлтгэгдсэн хэвлэлийн мэдээний орчуулга болно. Англи, монгол хувилбаруудын хооронд зөрүү эсвэл зөрчилдөх зүйл гарвал англи хэл дээрх хувийг мөрдөнө.

ЭНЭХҮҮ МЭДЭЭЛЛИЙГ ОЛОН НИЙТЭД ТАНИЛЦУУЛАХАД ЯМАРВАА НЭГЭН ЗАСАГ ЗАХИРГААНЫ БАЙГУУЛЛАГА ЗӨВШӨӨРСӨН, ҮЛ ЗӨВШӨӨРСӨН МЭДЭГДЭЛ ХИЙГЭЭГҮЙ.

Холбоо барих:

Петер К. Акерли, Ерөнхийлөгч болон гүйцэтгэх захирал
Роберт Женкинс, Санхүү хариуцсан захирал

Утас: (902) 423-6419
 И-мэйл: info@erdene.com
 Twitter: <https://twitter.com/ErdeneRes>
 Facebook: <https://www.facebook.com/ErdeneResource>
 LinkedIn: <https://www.linkedin.com/company/erdene-resource-development-corp/>

Хавсралт – Өрөмдлөгийн хураангуй – Дунджаар 0.30 г/т алтны агуулгаас дээш интервалуудыг танилцуулав

Цооног	м–ээс	м хүртэл	Интервал ⁽¹⁾	г/т алт
BKD-351	3.56	9	5.44	1.54
Түүнд	3.56	7	3.44	2.36
Ба	19	30 ⁽²⁾	11	0.53
BKD-352	6.5	26	19.5	2.51
Түүнд	10	24	14	3.33
Түүнд	18	23	5	6.20
Түүнд	19	20	1	15.06
BKD-353	15	24	9	0.55
BKD-354	0	7	7	11.79
Түүнд	5	6	1	67.54
BKD-355	10.5	30 ⁽²⁾	19.5	0.58
BKD-356	6	25.6 ⁽²⁾	19.6	3.10
Түүнд	7	17	10	5.72
Түүнд	15	16	1	39.60
BKD-357	0	15	15	0.59
Ба	24	26	2	1.09
BKD-358	10.3	26 ⁽²⁾	15.7	8.03
Түүнд	12	16	4	29.60
Түүнд	14	15	1	100.46
BKD-359	0	6	6	0.70
BKD-360	7	17	10	1.62
BKD-361	5	15	10	14.36
Түүнд	10	12	2	67.95
BKD-362	14	18	4	2.84
BKD-363	12	18	6	1.97
Түүнд	17	18	1	10.05
BKD-364	6	15.5 ⁽²⁾	9.5	1.66
BKD-365	0	7	7	1.07
Ба	17	23	6	1.37
Ба	27	28	1	0.62


BKD-366	15	18	3	0.44
Ба	23	29.5 ⁽²⁾	6.5	3.78
Түүнд	25	26	1	11.27
BKD-367	9	25	16	0.65
Түүнд	15	19	4	1.54
BKD-368	1	26 ⁽²⁾	25	1.00
Түүнд	2	3	1	16.96
BKD-369	0	20 ⁽²⁾	20	10.44
Түүнд	0	1	1	17.88
Түүнд	4	7	3	27.04
Түүнд	9	11	2	32.57
Түүнд	15	16	1	10.18
BKD-370	2.45	20 ⁽²⁾	17.55	4.78
Түүнд	2.45	9	6.55	10.64
Түүнд	6	7	1	30.51
Түүнд	8	9	1	10.89
BKD-371	0	5	5	9.27
Түүнд	1	3	2	21.45
Ба	13	15	2	0.48
BKD-372	0	5	5	1.13
Ба	8	9	1	0.47
Ба	18	22	4	5.69
Түүнд	19	20	1	12.02
BKD-373	0	10	10	0.64
BKD-374	7	20 ⁽²⁾	13	0.87
Түүнд	7	10	3	2.56
BKD-275	0	9	9	1.42

1. Тайлагнасан интервал нь цооногийн огтлолын зузаан болно. Нэмэлт хайгуул хийснээр бодит зузаан болон эрдэсжилтийн анизотропыг тодорхойлох боломжтой.
2. Цооногийн төгсгөл

THE KHUNDII GOLD DISTRICT – STAGES OF DEVELOPMENT

An Expanding Footprint of High-Grade Gold Deposits


Section Looking NW



BAYAN KHUNDII GOLD DEPOSIT PLAN MAP


High-Grade Starter Pit Targeting and Definition

- ≥ 0.4 g/t Gold Cut-off
- Starter Pit Target Drilling
- M+I Resource
- 585,100 oz Gold



Stage 1: Near Surface, High-Grade Starter Pit Targets

Section 1 Looking NE



Hole ID	Au Grade (g/t)	Interval (m)	Downhole Depth (m)	Notes
BKD352	6.2	5	18	Incl. 1m of 15 g/t Au
BKD354	11.8	7	From Surface	Incl. 1m of 67.5 g/t Au
BKD356	5.7	10	7	Incl. 1m of 39.6 g/t Au
BKD358	8	16	10	Incl. 4m of 29.6 g/t Au

Section 2 Looking NW



Hole ID	Au Grade (g/t)	Interval (m)	Downhole Depth (m)	Notes
BKD369	10.4	20	From Surface	Incl. 2m of 32.6 g/t Au
BKD370	10.6	6.5	2.5	Incl. 1m of 30.5 g/t Au
BKD371	9.3	5	From Surface	Incl. 2m of 21.5 g/t Au
BKD372	5.7	4	18	Incl. 1m of 12.0 g/t Au
BKD361	14.4	10	5	Incl. 2m of 68.0 g/t Au